

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Жамбал	Дугаар	L111
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Хэрлэн
Төрсөн газар	Өндөрхаан хот	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хурц ламын хийд	Сүм хийдийн дугаар	ХЭӨХ060
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 29	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Хэрлэн сумын Хурц ламын хийд

-Хурц ламын хийдийн тухай өөрийн мэдэх зүйлээ хэлж өгнө үү?

Хэдэн ламтай байсныг мэдэхгүй. Нэлээн олон ламтай нэлээн том хийд байсан. Их дуган цогчин дуган байсан. Лам нар бүгд хийдийн арын хүрээнд бүр дүүрээд суудаг байсан. Хурц лам хөдөө явдаггүй хийдээс гардаггүй номхон царайтай лам байсан. Сүүлд баригдаад голд хадлан дээр байсан гэж сонссон. Тэгээд өөд болсон байлгүй дээ.

-Ямар нэртэй газар байсан юм бол?

Хэрлэнгийн Хос арал гэдэг газар байсан гэсэн. Хийдээсээ баруун тийш Хөхөл хайрханаас хойшоо. Хадлан дээр байхад нь Жамбал гэдэг хүн эргэсэн гэдэг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Хэдэн онд байгуулагдсан хийд юм бол?

Оныг нь мэдэхгүй. Анх хийд байгуулах гээд явж байхад тэр газарт Төмөрэмээлт гээд нэг төвд сүүж байсан гэдэг. Айхтар номтой. Тэгээд зааны хошуу шинжтэй газар байна гээд тэрнийг хөөчихөөд буйран дээр нь хийдээ байгуулсан гэдэг. Тэр Төмөрэмээлт гэдэг төвдийг хөөгөөд явуулчихсан тэр Төмөрэмээлт Шастин гэдэг энэ баруун урд байдаг уулан дээр гараад хараал хийгээд хулгана жил юм гэнэ лээ. Тэгээд хулгана жил бүр цагаан бурхантаг тийм л хийд байсан юм гэнэ лээ. Тэр төвд хөөгдөнийхөө хороор хараал хийгээд тэгсэн юм гэнэ лээ. Тэгээд гахай жилийн намар их олон төвдүүдийг цуглуулаад гүрэм хийлгэсэн. Сүүлийн үед гайгүй л болсон юм гэнэ лээ. Намайг бага байхад манай ах ч тийм өвчин тусаад цоохор болсон хүн байсан. Манай ах жаахан цоохор шүү дээ. Чойр дуган цогчин дуган хоёр лав байсан. Аймгийн дуган байгаагүй. Чухам өөр ямар дуган байсныг мэдэхгүй юм. Манай эндэх шиг Жүдийн дуган, Манбын дуган гэж байгаагүй л болов уу? Манай эндэх (Гүндгаварлин) чинь өчнөөн олон дуган байсан. Баруун талд нь Цогчэн дуган, Зүүн талд нь Жүдийн дуган байсан. Тэгээд Мамба, Ёга, Дүйнхор дуганууд байсан. Гүрэмийн дуган хүртэл байсан гэдэг. Гүрэмийн дуган нь Зүүн хойно овоо байгаа тэнд байсан юм.

-Хурц ламын хийд гэдэг нь Хурц лам байгуулаад тэгж нэрлэсэн үү?

Түрүүчийн Хурц лам гэж айхтар хувилгаан хүн байсан гэдэг. Тэр би бол олонцогоо цоолно, миний дараах хүн олбогоо цоолно гэж ярьж байсан хүн байсан байгаа юм. Нэг айлд, өвгөн эмгэн хоёрын ороод надад нэг зузаан нэхий элдэж өгөөрэй гэж. Тэгээд нэхийг нь элдчихээд ав гэсэн. Болоогүй. Дараачийн лам тэднийд төрнө тэнд өгөөрэй гэсэн. Дараагийн лам ч тэр айлд төрсөн. Тэгээд тэр ламд нь нэхий очсон байгаа юм. Нэг хулгана жил Хурц лам зүүд зүүдэлсэн гэдэг. Баруун хойноос олон хятад жинчид ирж байна гэж зүүдлээд. Хийдийн сахиус болох Дамдинчойжоо сахиустай хамт хөөцөлдөөд дийлсэнгүй. Нэгийг оруулчихлаа гэж зүүдэлсэн гэдэг. Маргааш нь лам нар нь цагаан бурхантад гэсэн. Тийм айхтар лам байсан юм гэнэ лээ. Тэрний түрүүчийнх гэж ярьдаггүй л юм. Гүндгаварлингаас л арай хожуу байгуулагдсан.

-Хурц ламын хийдийн банди нар Гүндгаварлин хийдийн лам нар хоорондоо их зодолддог байсан. Тэгээд эв түнжигтэй байлгах гэж Гэлэн хөшөөг байгуулсан гэх юм.

Миний мэдэхийн л байсан. Урьд нь үхэр мал шөргөөгөөд байхад ердөө унадаггүй байсан мөртлөө. Хувьсгал гарснаас хойш л уначихаад байдаг болсон гэж лам нар ярьдаг байсан. Хятадууд босгосон гэж нэг дуулсан шүү. Сүүлд л хашаа машаа барьсан.

-Хурц ламын хийд хэр олон лам нартай байсан юм бол?

Яг сайн мэдэхгүй байна. Олон л байсан даа. Нэлээн том хийд байсан.

-Хууччуулын яриагаар их л сахилгагүй лам нартай байсан гэж сонсогддог?

Сахилгагүй нь ч юу вэ дээ. Хийдийн лам багачууд л их сахилгагүй байдаг байсан. Бид нар гучин хэдэн багачуул хар болоод аймгийн танхимд очоод оготно алаад хуучин хүүхдүүдийнхээ цүнхэнд чихээд хөөгдөөд аймгийн яамны дэргэд долоон гэр бариад 2 багштай 1 захиралтай тусгай сургууль болгоод дийлдэхгүй 3 сар

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

болоод бүгдийг тараасан. Ганц Бэх-Очир гэдэг хүүхэд байсан тэр аймгийн танхимд очиж суралцаад багш болсон.Тэрнээс бусад нь бүгд дийлдээгүй.

-Урд хийдэд, Гүндгаварлинд байгаа харанга нь Хурц ламын хийдийн харанга юм гэсэн.

Тэрийг мэдэхгүй. Сахиусыг нь Моломгэндэн гэдэг нэг хүн олоод хадгалж байсан. Тэрийг нь бурхан шашны эсрэг санаатай нэг хүн аваачаад шатаачихсан гэдэг. Тэгсэн тэр нь гадуураа нэг төмөр гэртэй байж байгаа д шаталгүй үлдсэнийг нь олж аваад хотод Гэсэрт байж байсан. Одоо байхгүй болсон гэдэг. Сүүлд Ламын хийдийн хэдэн лам нар байхдаа зуруулсан нь одоо энэ Дамдинчойжоо сахиус юм. Намайг бага байхад шар тос нь том модон поошигтой жавдангаасаа хаалга хүртэл урсаад тэндээс нь чавганц хүүхнүүд тосож авдаг байсан. Хийдийн хаяагаар борчууд гээд ядуу хүмүүс их байсан. Лам нараас юм гуйж иддэг.

Ламын хийдэд энэ хийдээс дутах юм ердөө байгаагүй. Цам, майдар гэж харин ердөө байгаагүй. Арван тавны чого гэж том хурал болдог байсан.

-Майдарыг нийлж хурдаг байсан гэсэн үү?

Нийлж хурдаг байсан. Хоёр хийд. Хурц лам, Гүндгаварлин хоёр.

-Яг хэдэн онд хаагдсан юм бэ?

1937,1938 оны л хавьд даа. Би цэрэгт 1937 онд явсан.Тэр хойгуур байхгүй болсон. Манай хийдийг дор нь нураасан. Гүндгаварлинг дараа нь нураасан. 1939 онд их дуган цэргийн склад болсон. Гүндгаварлингийн Цогчин дуганыг нураагаад голын баганыг нурааж чадахгүй намайг цэргээс ирэхэд ёрдойгоод байж байсан. Их дуганыг дүнзээр барьсан байсан сүүлд аймаг л авч хэрэглэсэн. Их сайхан дөрвөлжин зассан чулуунуудыг намын хорооны хундааманд хэрэглэсэн гэдэг. Ламын хийдийг мэдэх хүн одоо даанч байхгүй.

-Ламын хийдийн онцлох хурлуудын талаар сонссон юм байна уу?

Чойртой байсан. Өөр ямар дуган байсныг мэдэхгүй. Хайлан хурдаг байсан. Ламын хийд дээр хайлангаа хурдаг байсан байх даа. Хөдөөний хүмүүс айраг аваачаад айрагтай байдаг байсан. 15-ны чого гэж хурдаг байсан. Тэрийгээ хурж дуусаад амардаг. Амраад тоглоом болдог тийм л байсан. Хааяа ахынд очиж л харж байснаас тэр хийдийг би мэдэх биш. Тэнд сууж байгаагүй.

-Нүгнээ хурдаг байсан уу?

Нүгнээ хурдаг байсан. Дуугардаггүй сууж л байх. Найдан энэ тэр байсан.

Өөр танд санаж байгаа , онцолж хэлэх зүйл байна уу?

Байхгүй.

Таны ах лам чинь хэн гэдэг хүн байсан бэ?

Сүрэн гэдэг хүн байсан.21 хүртлээ лам байсан. Тэгээд цэрэгт явсан. Сая эргэж лам болж байгаад өнгөрсөн. Тэр хүн сайн мэдэх хүний нэг байсан.

Ламын Хийдэд таны ах тухайн үед ямар албан тушаал хашдаг байсан бол?

Гэвшийн дом тавьсан л байх.

Таны ахыг сууж байсан үеийн мяндагтан лам нарын нэрийг санаж байна уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мэдэхгүй.